

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН “ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын “Хөдөлмөрийн дотоод журам” болон төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомж, эрхийн акт нь энэхүү хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

1.2. Мал эмнэлгийн салбарын төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх нь төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, идэвхи санаачлагатай ажиллуулах үндсэн нөхцөл болно.

1.3. Энэхүү хөтөлбөрт тус Мал эмнэлгийн ерөнхий газар, харьяа байгууллага, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын нийт ажилтан албан хаагчид хамрагдана.

Хэрэгцээ шаардлага:

Судалгаанд хамрагдсан байгууллагууд: Аймаг, нийслэлийн мэл эмнэлгийн газар, харьяа газрууд, албан хаагчид оролцов.

Судалгаанд хамрагдсан хугацаа: 2019 оны 07-р сарын 01~ний өдөр

Судалгаанд хамрагдсан 21 байгууллагын батлагдсан орон тоо 1,043 байхаас 2019 оны 07-р сарын 01 ны байдлаар 814 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний 51,7% буюу 421 ажилтан, албан хаагч нь сум, дүүргийн мал эмнэлгийн тасагт ажиллаж байна.

- Нийт ажилчдын 62% нь төрийн захиргааны, 38% нь төрийн үйлчилгээний албан тушаалтан байна.
- Насны хувьд харьцангуй залуу буюу 34% нь 18-30, 31.6% нь 31-44 насныхан байна.
- Боловсон хүчний 85% нь дээд боловсролтой байгаагаас 7% нь магистр, 93% нь бакалаврын зэрэгтэй байна. 74.8% гэр болон хашаа байшинд амьдарч байна.
- Судалгаанд хамрагдсан 21 байгууллагын 10 нь өөрийн байранд, 11 нь аймгийнхаа ХХААГ-ын болон түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байна. Барилгын 60%, лабораторийн 67% нь 40 ба түүнээс дээш жилийн насжилттай байна.
 - Орон тооны хувьд Мал эмнэлгийн ерөнхий газар, харьяа байгууллагууд, Аймаг нийслэлийн Мал эмнэлгийн газар нийт батлагдсан бүтцийн дагуу 1271 албан хаагч томилогдон ажиллахаас 2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 1011 албан хаагч ажиллаж байна, Сул орон тоо 280 байна.

Дээрх байдлаас үзэхэд Мал эмнэлгийн ерөнхий газар, түүний харьяа болон орон нутгийн салбар байгууллагууд нь албан хаагчдынхаа амьдрах нөхцөлийг сайжруулах, хүүхдийн цэцэрлэгийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, амралт сувилалд явуулах зэргээр тодорхой асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна. Энэ нь албан хаагчдыг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай, идэвх санаачлагатай ажиллах гол нөхцөл болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтуудыг хэрэгжүүлсний үндсэн дээр Төрийн албаны болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан төрийн албан хаагчийн баталгаатай, тогтвортой, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2, Албан хаагчдыг албан тушаалын тодорхойлолтын дагуу эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэх боломжийг бий болгох үүднээс төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах арга замыг тодорхойлоход хөтөлбөрийн зорилт оршино.

Гурав. Хөтөлбөрийн зарчим, хэрэгжүүлэх хугацаа, үе шат, зохион байгуулалт

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим:

3.1.1. Хууль дээдлэх;

3.1.2. Төрийн албан хаагч бүр адил тэгш боломжтой байх;

3.1.3. Ил тод, нээлттэй хэрэгжүүлэх;

3.1.4. Бодитой, үр дүн нь тодорхой байх;

3.1.5. Нөөц бололцоог бүрэн дайчлах;

3.2. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үе шатууд;

3.2.1 Нэгдүгээр үе шат: 2019-2022

3.2.2 Хоёрдугаар үе шат: 2022-2024 он байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

3.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг агентлагийн дэд дарга удирдах ба зохион байгуулалт, хэрэгжилтийг Төрийн захиргаа, санхүү удирдлагын газар хариуцна.

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт

*

4.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

4.1.1. Байгууллагын жил бүрийн төсөв;

4.1.2. Байгууллагын төсвийн зарлагын хэмнэлт болон төсвийн урамшуулал;

4.1.3. Олон улсын болон дотоодын байгууллагын хандив тусламж;

4.1.4. Олонулсын байгууллага төсөл, хөтөлбөр;

4.1.5. Бусад эх уусвэр;

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.1. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгох,

5.1.1 Улсын Их хурал, Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан ажилтнуудын цалин, нэмэгдлийг тухай бүр шинэчлэн тогтоож олгоно.

5.1.2 Албан хаагчдад сар бүр хоол унааны зардлыг олгоно.

5.1.3 Албан хаагчдын жилийн ажлыг дүгнэж, хууль тогтоомжид заасны дагуу үр дүн, урамшууллын асуудлыг шийдвэрлэнэ.

5.1.4 Удирдлагын шийдвэрээр ажилтан, албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгож болно.

5.1.4 Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад байгууллагын зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

5.1.5 Сумын мал эмнэлгийн тасагт ажиллаж байгаа малын эмчид таван жил тутам нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг төрөөс олгоно.

5.1.6 Шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчний голомтод ажиллаж халдвар авсны улмаас, эсхүл албан үүргээ гүйцэтгэх үедээ амь насаа алдсан тохиолдолд түүний ар гэрт 36 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг төрөөс олгоно.

5.1.7 Мал, амьтны гоц халдварт өвчний голомтод, Мал, амьтны зрүүл мэндийн тухай хуулийн 19.1, 19.3-т заасан мэргэжлийн баг, ангийн бүрэлдэхүүнд дайчлагдан ажиллах бол хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлээр хангах, томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж дайчилгааг зохион байгуулсан байгууллагаас олгоно,

5.2 Албан хаагчдыг орон сууцжуулах, нөхцөлийг сайжруулах чиглэлээр:

5.2.1. Албан хаагчдын орон сууцны судалгааг төрөлжүүлэн гаргаж, түүнд үндэслэн орон сууц, хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцөлийг нь сайжруулахад хууль тогтоомжийн дагуу банкны урт хугацаатай хөнгөлөлттэй зээлд хамруулах, зохих санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

5.3. Ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэлээр:

5.3.1. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлыг “Төрийн албаны тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

5.3.2. Мал эмнэлгийн салбарын нэн тэргүүнд шаардлагатай зарим орон нутгийн мал эмнэлгийн газар, лабораторийн хуучирсан байшинд урсгал засвар хийх, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж жил бүрийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулж ажиллана.

5.3.3. Ажлын байрны тохижилт, шинэчлэлтийг орчин үеийн жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.3.4. Албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материаллаг бааз, компьютер, техник хэрэгсэл, вакцины зөөврийн хөргүүрээр хангах асуудлыг ажилтнуудаас санал авч судалгаа хийсний үндсэн дээр жил бүрийн хөрөнгө оруулалтын төсөвт тусгах замаар шийдвэрлэнэ.

5.3.5. Нийт аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрыг албан ажлын суудлын болон тусгай зориулалт бүхий авто машинаар хангах ажлыг үе шаттай зохион байгуулна.

5.3.6. Улсын хэмжээнд нийт 330 сумдын мал эмнэлгийн тасгийн ажилтнуудад мал, амьтныг өвчнөөс урьдчилан сэргийлэх, үзлэг оношлогоонд малчин өрхөөр явах мотоциклоор хангах ажлыг үе шаттай зохион байгуулна.

5.3.7. Ажилтнуудад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгохоос гадна мөнгөн бус урамшууллын апиваа аргыг судлан хууль тогтоомжид нийцүүлэн гадаад, дотоодод аялуулах зэргээр урамшуулна.

5.3.8. Шинээр гэр бүл болох, хүүхэд төрүүлэх, төр, засгийн шагналаар шагнуулах зэрэг албан хаагчдад баярт үйл явдал тохиолдоход нь байгууллагаас эд хөрөнгийн болон мөнгөн тусламж олгоно.

5.3.9. Хөдөлмөрийн чадвараа алдсан гэр бүлийн гишүүнээ тэтгэх, ажилтны өрхийн орлого буурч нэг гишүүнд ногдох хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй болсон, ар гэрт нь гачигдал тохиолдсон зэрэг нөхцөлд байгууллагаас нэг

удаагийн тэтгэмж, тусламж олгоно.

5.3.10. Ар гэрт нь гачигдал гарах, үр хүүхэд, төрсөн ах, дүү, хүүхэд нь хуримаа хийх, сургууль төгсөх, диплом, эрдмийн зэрэг хамгаалах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд цалинтай чөлөө олгоно.

5.4 Байгууллагын ажилтан, албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэх чиглэлээр:

5.4.1. Мал эмнэлгийн салбарын ажилтан албан хаагчдын дунд судалгаа явуулж байгууллагын дээд шатны нэгж, газар, хэлтсийн дарга, малын эмч, хяналтын улсын байцаагч, лабораторын ажилтан, тархвар зүйч, захиргаа, санхүүгийн ажилтан, албан хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагыг үндэслэн сургалтын тэргүүлэх чиглэлийг тогтооно.

5.4.2. Жил бүр ажилтан, албан хаагчдын сургалтын төлөвлөгөө боловсруулан гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллана.

5.4.3. Салбарын малын эмч, лабораторын ажилтан албан хаагчдад дунд богино хугацааны сургалтыг ХААИС-ын Мал эмнэлгийн сургууль, салбарын мэргэжлийн болон, төрийн бус байгууллага, холбоод, олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран зохион байгуулж, мэргэшлийн зэрэг олгох кредитийн үнэлгээний систем нэвтрүүлнэ.

5.4.4. Төрийн захиргааны албан хаагчдыг сургах даатан сургах чиглэлээр Төрийн албаны сургалтын байгууллага, удирдлагын академитай хамтран төрийн албаны мэргэшүүлэх, гарагийн болон урт дунд хугацааны, онлайн сургалтуудад хамруулна.

5.4.5. Албан хаагчдыг ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр бодлогын баримт бичиг боловсруулах, төрийн захиргааны онолын болон албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулна.

5.4.6. Мал эмнэлгийн байгууллагад мэргэжлээрээ таваас дээш жил ажиллаж байгаа малын эмчийг таван жил тутам мэргэжил дээшлүүлэх сургалтад улсын зардлаар хамруулна.

5.4.7. Ажилтнуудад гадаад хэлний мэдлэг боловсрол олгоход анхаарч, гадаад дотоодыг сургалт, хурал, зөвлөгөөн, уулзалтанд хамруулж, тухайн жилийн санхүүгийн боломжийг харгалзан дэмжлэг үзүүлж болно.

5.5. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

5.5.1. Албан хаагчдыг жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ хийлгэх, эмчлүүлэх шаардлагатай албан хаагчдыг тухай бүрт нь эмчилгээ, сувилгаа хийлгэх, витаминжуулалтад хамруулах зэрэг эрүүл мэндийг хамгаалахад нь дэмжлэг туслапцаа үзүүлнэ.

5.5.2. Албан хаагчдаа өвчлөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, спортын уралдаан тэмцээн зохион явуулах, 7 хоногт 1 удаа спорт зааланд тоглуулах, аэробек, бүжгийн секц, усан бассейнд явуулах зэрэг төрөл бүрийн спортын арга хэмжээнд хамруулж, салбарын болон байгууллагын спорт, биеийн тамирын тэмцээн арга хэмжээг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

5.5.3. Сум, дүүргийн мал эмнэлгийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байгаа бол жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд ажил олгогчийн зардлаар хамруулна.

5.5.4. Эрүүл мэндийн чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа албан хаагчдад яриа, танилцуулга хийлгэж, гарын авлага, материалаар хангана.

5.6. Ажилтан, албан хаагчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх чиглэлээр:

5.6.1. Баяр ёслол, амралтын өдрүүдийг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх,

аялал зугаалга зохион байгуулах, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулах зэргээр албан хаагчдыг үр бүтээлтэй амрах, алжаалаа тайлах нөхцөл бололцоогоор хангана.

5.6.2. Идэвхтэй хөдөлгөөн, идэвхтэй амралт, явган болон тойрон аяллыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

5.6.3. Байгууллагын ажиллагсдын хүүхдүүдийг зуны амралтаар нь зусланд хөнгөлөлттэй үнээр амруулах ажлыг зохион байгуулна.

Зургаа. Хөтөлбөрийн оролцогчид

6.1. Хөтөлбөр дараах оролцогч байгууллагуудтай байна. Үүнд:

6.1.1 Мал эмнэлгийн ерөнхий газар

6.1.2 Мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори

6.1.3 Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын төв лаборатори

6.1.4 Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн

7.1. Төрийн албан хаагчдыг ажиллах нөхцөл сайжирч, тогтвор суурьшилтай ажиллах боломж нэмэгдэнэ.

7.2. Төрийн албан хаагчдын нийгмийн халамж, дэмжлэг сайжирна.

7.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүрийн нэгдүгээр улиралд дүгнэж, хөтөлбөр, төлөвлөгөөнд тодотгол хийж, нэмэлт оруулж болно.